



АГААРЫН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
МАЛАЙЗ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Малайз Улсын
Засгийн газар,

Олон улсын иргэний агаарын тээврийн Конвенцид
оролцогчийн хувьд,

Монгол улс болон Малайз улсын нутаг дэвсгэр
хооронд болон тэдгээрийн чанадад агаарын харилцаа
тогтоон хөгжүүлэх зорилгоор,

дараах зүйлийг тохиров:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

ТОДОРХОЙЛОЛТ

1. Энэхүү Хэлэлцээр болон түүний Хавсралтанд
дурдсанаас утга санаа нь өөрөөр заагаагүй бол:

а. "Хэлэлцээр" гэж энэхүү Хэлэлцээр, түүний
Хавсралт болон тэдгээрт оруулсан аливаа нэмэлт
өөрчлөлтийг хэлнэ;

б. "Конвенц" гэж 1944 онм 12 дугаар сарын 7-нм
өдөр Чикаго хотноо гарын үсэг зурсан Олон улсын
иргэний агаарын тээврийн Конвенцийг хэлэх, түүнчлэн
энэ Конвенцийн 90 дүгээр зүйлийн дагуу батлагдсан
хавсралтууд болон түүний 90, 94 дүгээр зүйлийн дагуу
тухайн Конвенц, түүний хавсралтуудад орсон аливаа
нэмэлт өөрчлөлтийг хамруулах бөгөөд хавсралт болон
нэмэлт өөрчлөлтүүд нь Хэлэлцэн тохирогч хоёр Талын
хувьд хүчин төгөлдөр байна.

в. "Агаарын тээврийн захиргаа" гэж Монгол Улсын
хувьд Монгол улсын Дэд бүтцийн хөгжлийн сайд буюу



түүний одоо эрхэлж байгаа үүргийг гүйцэтгэх эрх олгогдсон аливаа байгууллага болон бие хүнийг; Малайз Улсын хувьд Тээврийн сайд буюу түүний одоо эрхэлж байгаа үүргийг гүйцэтгэх эрх олгогдсон аливаа байгууллага, бие хүнийг хэлнэ;

г."Томилогдсон агаарын тээврийн байгууллага" гэж энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн дагуу томилогдож, эрх олгогдсон агаарын тээврийн байгууллагыг хэлнэ;

д."Нутаг дэвсгэр" гэж тухайн улс орны хувьд Конвенцийн 2 дугаар зүйлд заасныг хэлнэ;

е."Агаарын харилцаа", "олон улсын агаарын харилцаа", "агаарын тээврийн байгууллага", "тээвэрлэлтийн бус зорилготой буулт" гэсэн нэр томъёонууд нь Конвенцийн 96 дугаар зүйлд зааса. утга санааг тус бүр агуулна;

ж."Тогтоосон шугам" гэж энэхүү Хэлэлцээрийн хавсралтанд заасан аливаа шугамыг хэлнэ;

з."Тохиролцсон үйлчилгээ" гэж тогтоосон шугамаар явуулах агаарын тээврийн үйлчилгээг хэлнэ.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЭРХ ОЛГОХ

1.Хэлэлцэн тохирогч Тал бүр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын томилогдсон агаарын тээврийн байгууллагад энэхүү Хэлэлцээрт дурдсан тохиролцсон үйлчилгээг явуулах эрх олгоно.

2.Хэлэлцэн тохирогч Тал бүрийн томилогдсон агаарын тээврийн байгууллага нь энэхүү Хэлэлцээрийн заалтуудын хүрээнд дараах эрхийг эдэлнэ:

а.Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт буултгүйгээр дамжин өнгөрөх;

б.Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт тээвэрлэлтийн бус зорилготой буулт хийх;

в.Тохиролцсон үйлчилгээг явуулахдаа олон улсын зорчигч, ачаа, шууданг дангаар буюу хамтад нь тээвэрлэхээр авах буюу буулгах зорилгоор тогтоосон



шугамын дагуух Хавсралтанд заасан Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээрх цэгүүдэд буулт хийх.

3.Энэхүү зүйлийн 2 дугаар заалтыг Хэлэлцэн тохирогч нэг талын томилогдсон агаарын тээврийн байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээрх нэг цэгээс нөгөөд ашиг олох зорилгоор тээвэрлэлт хийх эрх олгохгүй гэж ойлгоно.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

ТОМИЛОХ, ЭРХ ОЛГОХ

1.Хэлэлцэн тохирогч Тал бүр тогтоосон шугамаар тохиролцсон үйлчилгээ явуулахаар нэг агаарын тээврийн байгууллагыг томилох эрхтэй бөгөөд энэ тухай Хэлэлцэн тохирогч нөгөө Талд бичгээр мэдэгдэнэ.

2.Хэлэлцэн тохирогч нөгөө Тал ийм мэдэгдлийг авмагц энэ зүйлийн 3, 4 дүгээр заалтын дагуу үйл ажиллагаа явуулах эрхийг томилогдсон агаарын тээврийн байгууллагад олгоно.

3.Хэлэлцэн тохирогч нэг Талын агаарын тээврийн захиргаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын томилогдсон агаарын тээврийн байгууллагаас Конвенцийн заалтуудын дагуу явуулах олон улсын агаарын тээврийн үйлчилгээнд ийм агаарын тээврийн захиргаадаас мөрдлөг болгодог хууль тогтоомжийн нөхцөл шаардлагыг биелүүлж чадна гэсэн нотолгоог шаардаж болно.

4.Агаарын тээврийн байгууллагын өмчийн дийлэнх хэсэг эзэмшилд нь байгаа болон үйл ажиллагаанд нь тавих үр нөлөөтэй хяналт тухайн агаарын тээврийн байгууллагыг томилсон Хэлэлцэн тохирогч Тал буюу түүний иргэдэд байгаа эсэхэд эргэлзсэн тливаа тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талууд энэ зүйлийн 2-т заасан зөвшөөрөл олгохоос татгалзах, эсвэл энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан эрхийг эдлүүлэхэд зайлшгүй гэж үзэж байгаа болзол, нөхцөл тавих эрхтэй.

5.Энэ зүйлийн 1, 2 дугаар заалтын дагуу томилогдож, эрх авсан агаарын тээврийн байгууллагууд энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг дагаж мөрдөх тохиолдолд тохиролцсон үйлчилгээг хэзээ ч эхэлж болно.



ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

ЭРХИЙГ ЦУЦЛАХ

1. Хэлэлцэн тохирогч Тал бүр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын томилогдсон агаарын тээврийн байгууллагад олгосон эрхээ цуцлах буюу энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 2-т заасан эрхийг эдлүүлэхийг түр зогсоох, эсвэл эдгээр эрхийг эдлүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн болзол, нөхцөлийг дор дурдсан тохиолдолд тавих эрхтэй:

а. агаарын тээврийн байгууллагын өмчийн дийлэнх хэсэг эзэмшилд нь байгаа болон үйл ажиллагаанд нь тавих үр нөлөөтэй хяналт тухайн агаарын тээврийн байгууллагыг томилсон Хэлэлцэн тохирогч Тал буюу түүний иргэдэд байгаа эсэхэд эргэлзсэн аливаа тохиолдолд;

б. тухайн агаарын тээврийн байгууллагад эрх олгосон Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүй бол.

в. тухайн агаарын тээврийн байгууллага ямар нэг байдлаар энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг дагаж мөрдөөгүй бол.

2. Хууль тогтоомжийг цаашид зөрчих явдлыг таслан зогсоох үүднээс нэн даруй хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гараагүй бол энэ зүйлийн 1-д заасан цуцлах, түр зогсоох, болзол нөхцөл тавих эрхийг зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын агаарын тээврийн захиргаатай зөвлөлдсөний дараа эдлүүлнэ.

ТАВДУГААР ЗҮЙЛ

ХУУЛЬ ТОГТООМЖ БОЛОН БУСАД ЖУРМЫГ МӨРДӨХ

1. Олон улсын агаарын харилцаанд ашиглагдаж байгаа агаарын хөлгийг нутаг дэвсгэртээ орвулах, гаргах, эсвэл нутаг дэвсгэрийнхээ хил хязгаарын дотор тухайн агаарын хөлгийн нислэг болон навигацитай холбогдолтой асуудлыг зохицуулдаг Хэлэлцэн тохирогч нэг Талын хууль тогтоомж болон бусад журмыг агаарын тээврийн байгууллагууд дагаж мөрдөнө.



2.Зорчигч, нисэх баг, ачаа, шууданг нутаг дэвсгэртээ оруулах, түр байлгах, гаргах ажиллагааг зохицуулдаг Хэлэлцэн тохирогч нэг Талын хууль тогтоомж, тухайлбал орох, гарах, цагаачлах, паспорт, гааль, валют болон хорио цээрийн хяналтын дүрэм журмыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын томилогдсон агаарын тээврийн байгууллагын тээвэрлэж буй зорчигч, нисгэх баг, ачаа, шуудангийн хувьд дагаж мөрдөнө.

3.Хэлэлцэн тохирогч Талууд энэ зүйлийн 1, 2-т заасан хууль тогтоомж болон бусад журмуудыг хэрэгжүүлэхдээ аливаа нэг өөр агаарын тээврийн байгууллагыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын томилогдсон агаарын тээврийн байгууллагаас илүүд үзэхгүй.

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

АГААРЫН ТЭЭВРИЙН БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛӨЛ

1.Хэлэлцэн тохирогч Тал бүр өөрийн нутаг дэвсгэрт төлөөлөгчийн газар байгуулах эрхийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын агаарын тээврийн байгууллагад олгоно. Ийм төлөөлөгчийн газар нь удирдлага, худалдаа, үйлчилгээ, техникийн ажилтнуудтай байж болно. Төлөөлөгчийн газар болон ажилтнуудыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр хууль тогтоомжийн дагуу байгуулах буюу томилно.

ДОЛДУГААР ЗҮЙЛ

АШИГ ОЛОХ ЗОРИЛГООР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ

1.Хэлэлцэн тохирогч Талууд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын томилогдсон агаарын тээврийн байгууллагад өөрийн нутаг дэвсгэрт шууд буюу шаардлагатай гэж үзвэл төлөөлөгчөөр дамжуулан агаарын тээврийн үйлчилгээ явуулах эрх олгоно. Томилогдсон агаарын тээврийн байгууллага нь уг нутаг дэвсгэрт үйлчлэх мөнгөн тэмдэгт буюу тухайн орны үндэсний хуулиар зөвшөөрөгддөг бусад гадаад чөлөөт хөрвөх валютаар өөрийн үйлчилгээг борлуулах эрх эдлэнэ.

2.Хэлэлцэн тохирогч Талууд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын томилогдсон агаарын тээврийн байгууллагад нутаг дэвсгэрт нь явуулж буй



тохиролцсон үйлчилгээтэй холбогдсон зарлагаас давсан орлогыг өөрийн улс руу шилжүүлэхдээ нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулж буй оронд үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд чөлөөтэй шилжүүлэх эрх олгоно.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

ҮНЭМЛЭХ, ГЭРЧИЛГЭЭГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ

Хэлэлцэн тохирогч нэг Талаас олгосон, хүчин төгөлдөр байгаа нислэгт тэнцэх тухай гэрчилгээ, эрх олгосон гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх, лицензийг Хэлэлцэн тохирогч нөгөө Тал хүчин төгөлдөр гэж тооцно. Хэлэлцэн тохирогч Тал бүр өөрийн нутаг дэвсгэр дээгүүрх нислэгийн тухайд Хэлэлцэн тохирогч нөгөө Талаас өөрийнх нь иргэдэд олгосон эрх олгосон гэрчилгээ, үнэмлэх лицензийг хүчин төгөлдөрт тооцохоос татгалзах эрхтэй байна.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАР ХУРААМЖУУДААС ЧӨЛӨӨЛӨХ

1.Хэлэлцэн тохирогч Тал бүрийн томилогдсон агаарын тээврийн байгууллагаас олон улсын агаарын тээврийн үйлчилгээнд ашиглаж байгаа агаарын хөлөг түүнчлэн хөлгийн бүхээгт байгаа байнгын тоноглол, сэлбэг хэрэгсэл, шатахуун, тослох материал, бүхээгийн нөөц (хоол, хүнс, ундаа тамхийг оролцуулан) зэрэг нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ороход бүхий л гаалийн татвар, үзлэг, шалгалтын хураамж болон бусад татвар хураамжаас чөлөөлөгдөнө. Дээрх тоноглол, нөөц материалууд нь онгоц буцаж нисэх хүртэл бүхээгт хадгалагдана.

2.Хэлэлцэн тохирогч нэг Талын томилогдсон агаарын тээврийн байгууллагын болон түүнийг төлөөлж Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оруулсан буу тэнд нь хүлээж авсан шатахуун, тослох материал, сэлбэг хэрэгсэл, байнгын тоноглол, бүхээгийн нөөц зэргийг уг агаарын тээврийн байгууллага зөвхөн олон улсын агаарын тээврийн үйлчилгээнд зориулж агаарын хөлгийн бүхээгт ашиглана гэж үзэж Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээрх шугамын хэсэгт үйлдэх нислэгт хэрэглэгдэх байсан ч гэсэн Хэлэлцэн тохирогч тухайн Талын гаалийн татвар, үзлэг хяналтын зэрэг үндэсний



татвар, хураамжаас чөлөөлнө. Дээр дурдсан зүйлсийг гаалийн хяналтын дор хадгалахыг шаардаж болно.

3.Хэлэлцэн тохирогч аль нэг Талын агаарын хөлгийн бүхээгт хадгалагдаж байгаа шатахуун, тослох материал, сэлбэг хэрэгсэл, байнгын тоноглол, бүхээгийн нөөц зэргийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт буулгахдаа тухайн Хэлэлцэн тохирогч Талын гаалийн байгууллагын зөвшөөрлийг авна. Гаалийн байгууллага нь дээрх зүйлсийг буцааж авч явах, эсвэл тухайн гаалийн журмын дагуу хэрэглэх хүртэлх хугацаанд өөрийн хяналтын дор байлгахыг шаардаж болно.

4.Хэлэлцэн тохирогч нэг Талын томилогдсон агаарын тээврийн байгууллагын Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хүлээж авсан шатахуун, тослох материал, сэлбэг хэрэгсэл, байнгын тоноглол, бүхээгийн нөөц зэргийг уг агаарын тээврийн байгууллага зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээрх хоёр цэгийн хооронд үйлдэх нислэгт ашиглана гэж үзэж түүнд ноогдуулах гаалийн татвар, үзлэг хяналтын зэрэг үндэсний болон орон нутгийн бусад татвар, хураамжийн хэмжээ нь уг Хэлэлцэн тохирогч Тал өөрийн үндэсний агаарын тээврийн байгууллагад ноогдуулдаг татвар хураамжийн хэмжээнээс илүүгүй байна.

АРАВДУГААР ЗҮЙЛ

БАГТААМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТ

1.Хэлэлцэн тохирогч Талуудын томилогдсон агаарын тээврийн байгууллагууд тэдгээрийн нутаг дэвсгэрийн хооронд тогтоосон маршрутаар тохиролцсон үйлчилгээг эрхлэн явуулахдаа шударга бөгөөд ижил боломжоор хангагдана.

2.Хэлэлцэн тохирогч нэг Талын томилогдсон агаарын тээврийн байгууллага тохиролцсон үйлчилгээг эрхлэн явуулахдаа тухайн маршрут буюу түүний хэсэгт үзүүлж буй агаарын тээврийн байгууллагын тээвэрлэлтэд хохирол учруулахгүйн тулд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын томилогдсон агаарын тээврийн байгууллагын ашиг сонирхлыг харгалзан үзнэ.

3.Хэлэлцэн тохирогч Талуудын томилогдсон агаарын тээврийн байгууллагуудын эрхлэн явуулж буй тохиролцсон үйлчилгээ нь тогтоогдсон маршрутаар



нийтийн тээврийн хэрэгцээтэй нягт уялдах ёстой бөгөөд тухайн агаарын тээврийн байгууллагыг томилсон Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэр рүү буюу нутаг дэвсгэрээс өнөөгийн болон цаашдын зохистой төлөвлөгдөж буй зорчигч, ачаа, шуудан тээвэрлэх хэрэгцээг даац ашиглалтын зохистой түвшинд хангахуйц багтаамжийг олгох нь энэ үйлчилгээний эн тэргүүний зорилго байх болно. Тухайн агаарын тээврийн байгууллагыг томилсноос өөр бусад улсын нутаг дэвсгэр дээрх тогтоосон маршрутын цэгүүдэд авах буюу буулгах зорчигч, ачаа, шуудангийн тээвэрлэлт нь дор дурдсан зүйлээс багтаамж хамаарч байх ерөнхий зарчимд нийцсэн байх ёстой. Үүнд:

(а) тухайн агаарын тээврийн байгууллагыг томилсон Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэр рүү буюу нутаг дэвсгэрээс тээвэрлэх хэрэгцээ;

(б) орон нутгийн болон бүс нутгийн тээвэрлэлтийг харгалзан тогтоосон агаарын тээврийн байгууллагын дайран өнгөрч буй бүс нутгийн тээврийн хэрэгцээ;

(в) дамжин өнгөрөлтийн тээврийн хэрэгцээ.

АРВАННЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

ТАРИФ

1. Дараах заалтуудын зорилгын үүднээс "тариф" гэсэн тодорхойлолт нь зорчигч болон ачаа тээвэрлэхэд төлөх үнэ хөлс болон агентын болон бусад нэмэгдэл үйлчилгээний үнэ ба нөхцөлийг оруулан /гэвч шуудан тээвэрлэх хөлс ба нөхцөлийг оруулахгүйгээр/ эдгээр үнэ хөлсийг хэрэглэх нөхцөлүүдийг хэлнэ.

2. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр рүү болон нутаг дэвсгэрээс тээвэрлэхэд Хэлэлцэн тохирогч нэг Талын агаарын тээврийн байгууллагын нэхэмжлэн авах тарифыг ашиглалтын зардал, зүй зохистой ашиг болон агаарын тээврийн бусад байгууллагуудын тариф зэрэг холбогдох бүх хүчин зүйлсийг харгалзан зүй зохистой түвшинд тогтооно.

3. Энэ зүйлийн (2) заалтад заасан тарифыг хэрэв боломжтой бол Хэлэлцэн тохирогч хоёр Талын томилогдсон агаарын тээврийн байгууллагууд хооронд тохирох бөгөөд ийм тохиролцоонд бололцоонм хирээр



Олон улсын агаарын тээврийн нийгэмлэгийн дэг журмыг ашиглан хүрэх ёстой.

4.Хэрэв тарифыг энэ зүйлийн (3) заалтын дагуу тохирч чадаагүй бол, Хэлэлцэн тохирогч хоёр Талын агаарын тээврийн захиргаад зохих тарифын талаар тохиролцоонд хүрэхийг эрмэлзэх болно.

5.Хэрэв энэ зүйлийн (4) заалтын дагуу хоёр талын агаарын тээврийн захиргаад тохиролцоонд хүрч чадаагүй бол маргааныг энэ Хэлэлцээрийн 15 дугаар зүйлийн дагуу шийдвэрлэнэ.

АРВАНХОЁРДУГААР ЗҮЙЛ

МЭДЭЭЛЭЛ БА ТОО БҮРТГЭЛ

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын агаарын тээврийн захиргаа нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын агаарын тээврийн захиргааг түүний хүсэлтээр Хэлэлцэн тохирогч эхний Талын томилогдсон агаарын тээврийн байгууллагын эрхлэн явуулж буй тохиролцсон үйлчилгээний багтаамжийг эргэн хянах зорилгоор зүй зохистойгоор шаардагдаж болох тоо бүртгэлийн тогтмол буюу бусад мэдээллээр хангах болно. Эдгээр мэдээлэлд томилогдсон агаарын тээврийн байгууллагын тохиролцсон үйлчилгээн дэх тээвэрлэлтийн хэмжээг тодорхойлоход шаардагдах бүх мэдээллийг агуулсан байх ёстой.

АРВАНГУРАВДУГААР ЗҮЙЛ

НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

1.Олон улсын хуулиар өөрсдийн хүлээсэн эрх үүргийн дагуу иргэний агаарын тээврийн аюулгүй байдалд харшлах хууль бус хөндлөнгийн үйлдлээс хамгаалах талаар харилцан хүлээсэн үүрэг нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэдгийг Хэлэлцэн тохирогч Талууд нотолж байна. Хэлэлцэн тохирогч Талууд олон улсын хууль зүйн дагуу хүлээсэн эрх үүргийнхээ ерөнхий шинж чанарыг хязгаарлахгүйгээр 1963 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Токио хотноо гарын үсэг зурсан Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон бусад тодорхой үйлдлийн тухай Конвенц, 1970 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Гааг хотноо гарын үсэг зурсан Агаарын хөлгийг хууль бусаар булаан авахтай тэмцэх тухай Конвенц, 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Монреал



хотноо гарын үсэг зурсан Иргэний агаарын тээврийн найдвартай байдлын эсрэг чиглэсэн хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай Конвенц болон хоёр Тал гишүүнээр нэгдсэн иргэний нисэхийн аюулгүй байдлыг хамаарах аливаа бусад конвенциудын заалтуудыг дагаж мөрдөнө.

2.Хэлэлцэн тохирогч Талууд өөрсдийн хууль тогтоомжийн дагуу агаарын хөлөг, түүний зорчигч, нисгэх баг түүнчлэн нисэх буудал, агаарын навигацийн хэрэгслийн найдвартай байдлын эсрэг чиглэсэн хууль бус үйлдлүүд болон Иргэний агаарын тээврийн аюулгүй байдлын эсрэг аливаа аюул заналаас урьдчилан сэргийлэх талаар хүсэлт авмагц бүхий л шаардлагатай туслалцааг харилцан бие биедээ үзүүлнэ.

3.Хэлэлцэн тохирогч Талууд өөр хоорондын харилцаанд Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагаас тогтоосон болон Олон улсын иргэний агаарын тээврийн Конвенцийн Хавсралтуудад заасан аюулгүй байдлын заалтуудыг мөрдлөг болгох бөгөөд чингэхдээ өөртөө хамаарах аюулгүй байдлын заалтуудыг хэрэгжүүлнэ. Хэлэлцэн тохирогч Талууд өөрсдийн агаарын тээврийн байгууллагууд болон өөрсдийн нутаг дэвсгэр дээрх нисэх буудал ашиглагч нараас нисэхийн аюулгүй байдлын эдгээр заалтыг мөрдөн ажиллахыг шаардана.

4.Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр рүү орох, гарах болон түүний хил хязгаарын дотор байх үед энэ зүйлийн 3-т заасан нисэхийн аюулгүй байдлын талаарх заалтуудыг мөрдөж ажиллахыг агаарын тээврийн байгууллагуудаас шаардаж байхаар Хэлэлцэн тохирогч Талууд тохиров. Хэлэлцэн тохирогч Тал бүр өөрийн нутаг дэвсгэрт агаарын хөлгийг хамгаалах түүнчлэн зорчигчид, нисгэх баг, тээвэрлэгдэх эд зүйлс, тээш, ачаа, бүхээгийн нөөцийг ачихаас өмнө болон ачих үеэр үзлэг шалгалт хийхтэй холбогдсон зохих арга хэмжээ авна. Хэлэлцэн тохирогч Тал бүр тодорхой аюулын эсрэг аюулгүй байдлын зохистой тусгай арга хэмжээ авах талаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талын аливаа хүсэлтийг нааштай хүлээн авна.

5.Агаарын хөлөг, түүний зорчигчид болон нисгэх баг, түүнчлэн нисэх буудал, агаарын навигацийн хэрэгслийн найдвартай байдлын эсрэг чиглэсэн хууль бус хөндлөнгийн үйлдэл гарсан буюу гарах аюул тулгарсан үед Хэлэлцэн тохирогч Талууд холбоо барьж, ийм үйлдэл буюу аюулыг найдвартайгаар түргэн таслан



зогсооход чиглэгдсэн зохих арга хэмжээг авах замаар харилцан бие биедээ туслалцаа үзүүлнэ.

АРВАНДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

ЗӨВЛӨЛДӨХ

Энэхүү Хэлэлцээр болон түүний Хавсралтын заалтуудыг дагаж мөрдөх, хэрэгжилтийг хангахын үүднээс Хэлэлцэн тохирогч Талуудын агаарын тээврийн захиргаад нягт хамтран ажиллах зорилгоор үе үе зөвлөлдөж байна. Мөн түүнчлэн Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарвал зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.

Хэлэлцэн тохирогч аль ч Тал зөвлөлдөх хүсэлт тавьж болно. Хэлэлцэн тохирогч Талууд тогтсон хугацааг сунгахаар тохироогүй бол ийм зөвлөлдөөнийг хэлэлцээ хийх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

2.Хэрэв Хэлэлцэн тохирогч Талууд асуудлыг хэлэлцээний замаар шийдвэрлэж эс чадвал Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүсэлтээр маргааныг шийдвэрлүүлэхээр хөндлөнгийн шүүхэд хандаж болох бөгөөд Хэлэлцэн тохирогч Тал тус бүр нижгээд хөндлөнгийн шүүгчийг томилно. Ийнхүү томилогдсон 2 хөндлөнгийн шүүгч нь гуравдагч хөндлөнгийн шүүгчийг тохирох бөгөөд гуравдагч хөндлөнгийн шүүгч нь Хэлэлцэн тохирогч аль ч Талын иргэн бус байна. Гуравдагч хөндлөнгийн шүүгч нь хөндлөнгийн шүүхийн Ерөнхийлөгчөөр ажиллана. Маргааныг хөндлөнгийн шүүхээр шийдвэрлүүлэх тухай Хэлэлцэн тохирогч аль нэг Талын дипломат нотыг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор өөрийн нижгээд хөндлөнгийн шүүгчийг томилох ба гуравдагч хөндлөнгийн шүүгчийг түүний дараах 60 хоногийн дотор томилно. Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь 60 хоногийн хугацаанд өөрийн хөндлөнгийн шүүгчийг томилж чадаагүй буюу эсвэл гуравдагч хөндлөнгийн шүүгчийг дурдсан хугацаанд тохироогүй бол Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүсэлтээр Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагын Зөвлөлийн Ерөнхийлөгч тухайн нөхцөл байдлыг харгалзан нэг буюу хэд хэдэн шүүгчийг томилно.

3.Хэлэлцэн тохирогч Талууд энэ зүйлийн 2 дугаар заалтын дагуу гаргасан аливаа шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.



4.Хэлэлцэн тохирогч Талууд өөрсдийн хөндлөнгийн шүүгчийн зардлыг хариуцна. Хөндлөнгийн шүүхийн бусад зардал нь (гуравдагч хөндлөнгийн шүүгчийн хөлс зардлыг оруулна) тэнцүү хэмжээгээр хуваагдана.

АРВАНЗУРГАДУГААР ЗҮЙЛ

НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

1.Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Тал энэхүү Хэлэлцээрийн аливаа заалтыг өөрчлөх нь зүйтэй гэж үзвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Талд зөвлөлдөх хүсэлт тавьж болно. Ийм зөвлөлдөөнийг Агаарын тээврийн захиргаадны хооронд хийж болох бөгөөд хэлэлцээ хийх буюу эсвэл захидлаар харилцах замаар явуулж болно. Хэлэлцэн тохирогч хоёр Тал өөрөөр тохироогүй бол зөвлөлдөөнийг хүсэлт тавьсан өдрөөс хойш 60 хоногийн дотор эхэлнэ. Ийнхүү тохирсон аливаа өөрчлөлт нь дипломат нот солилцон баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно. Хэлэлцэн тохирогч Талуудын агаарын тээврийн захиргаад хоорондоо шууд тохирсноор Хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах ба ийм өөрчлөлт нь агаарын тээврийн захиргаадны баталсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

АРВАНДОЛДУГААР ЗҮЙЛ

ОЛОН ТАЛЫН ХЭЛЭЛЦЭЭРҮҮДИЙГ МӨРДӨХ

Агаарын тээвэрт хамаарах аливаа олон талын хэлэлцээр байгуулагдаж түүнд Хэлэлцэн тохирогч Талууд нэгдэн орвол тэрхүү хэлэлцээрт уялдуулах үүднээс энэхүү Хэлэлцээрт зохих нэмэлт өөрчлөлт оруулна.

АРВАННАЙМДУГААР ЗҮЙЛ

ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ЦУЦЛАХ

Хэлэлцэн тохирогч нэг Тал энэхүү Хэлэлцээрийг цуцлах тухай шийдвэрээ хэлэлцэн тохирогч нөгөө Талд хэдийд ч дипломат шугамаар мэдэгдэж болно. Энэ мэдэгдлийн хуулбарыг Олон улсын Иргэний агаарын тээврийн байгууллагад нэгэн зэрэг өгнө.

Хэлэлцэн тохирогч нөгөө тал хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш 12 сарын дотор Хэлэлцэн тохирогч Талууд тохиролцоонд хүрч мэдэгдлийг буцаагаагүй тохиолдолд хэлэлцээрийг



цуцалсанд тооцно. Харин Хэлэлцэн тохирогч нөгөө Тал мэдэгдлийг хүлээн авсан тухайгаа хариу мэдэгдээгүй бол Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага уг мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дараа Хэлэлцэн тохирогч нөгөө Тал түүнийг хүлээн авсанд тооцно.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

БҮРТГҮҮЛЭХ

Энэхүү Хэлэлцээр болон түүнд оруулсан аливаа нэмэлтүүдийг Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагад бүртгүүлнэ.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ

ЗҮЙЛҮҮДИЙГ НЭРЛЭХ

Энэхүү Хэлэлцээрийн үүднээс зүйл тус бүрт нэр өгсөн буюу тэдгээр нь энэхүү Хэлэлцээрийн зорилго, цар хүрээг тодорхойлж, хязгаарлах эсвэл тайлбарлахгүй билээ.

ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч Тал бүрийн хууль тогтоомжийн дагуу батлагдаж түүнийг хэлэлцэн тохирогч Талууд харилцан дипломат нот солилцож баталгаажуулсан өдөр хүчин төгөлдөр болно.

Энд өгүүлсэн зүйлийг батлан гэрчилж, өөрсдийн Засгийн газруудаас олгосон бүрэн эрхийн дагуу энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү Хэлэлцээрийг 1997 оны 9 дүгээр сарын 09-ны өдөр Ниаанбаатар хотноо малайз, монгол болон англи хэлээр үйлдсэн бөгөөд бүх хувиуд утга санаа агуулгын хувьд адил болно.

Хэрэв энэхүү хэлэлцээрийг тайлбарлахад маргаан гарвал англи хэл дээрх эхийг баримтлана.

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС

МАЛАЙЗ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС



Х А В С Р А Л Т

Монгол улсаас томилогдсон агаарын тээврийн байгууллагууд дараах шугамаар агаарын тээврийн үйлчилгээ явуулна.

Монгол улс дахь цэгүүд	Завсрын цэгүүд	Малайз улс дахь цэгүүд	Цаашид орших цэгүүд
Улаанбаатар	Сөүл, Бангкок	Куала Лумпур	Сингапур

Малайз улсаас томилогдсон агаарын тээврийн байгууллагууд дараах шугамаар агаарын тээврийн үйлчилгээ явуулна.

Малайз улс дахь цэгүүд	Завсрын цэгүүд	Монгол улс цэгүүд	Цаашид орших цэгүүд
Малайз улс дахь цэгүүд	Сөүл, Бээжин Шанхай	Улаанбаатар	Москва

1.Томилогдсон агаарын тээврийн байгууллага бүр өөрийн үзэмжээр тогтоосон шугамн дагуух аль нэг болон завсрын бүх цэгүүд эсвэл цааш орших цэгүүдийг тухайн буюу бүх нислэгтээ алгасч болох бөгөөд ийм тохиолдолд энэхүү олон улсын нислэгийн эхлэх, төгсөх цэгүүд нь тухайн байгууллагыг томилсон хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт байх ёстой.

2.Хэлэлцэн тохирогч аль нэг Талыг томилогдсон агаарын тээврийн байгууллага нь завсрын болон цааш орших аль ч цэгүүдэд үйлчилгээ явуулж болох бөгөөд тэдгээр цэгүүд болон Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр хооронд нислэг үйлдэхдээ тээвэрлэлтийн 5 дугаар эрхийг эдлэхгүй. Хэлэлцэн тохирогч аль нэг Талын томилогдсон агаарын тээврийн байгууллагууд тээвэрлэлтийн 5 дугаар эрхийг эдэлж болох бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө талын агаарын тээврийн захиргаанаас урьдчилан зөвшөөрөл авсан байх ёстой.